



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 114.

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын албан ажлын хэрэгцээнд зориулан үйл ажиллагааны давсан орлого болон өөрийн орлогын эх үүсвэрээр 631,500,000.00 (зургаан зуун гучин нэгэн сая таван зуун мянган) төгрөгт багтаан 16 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



0000225

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 08 дугаар сарын 3/- ны өдрийн
114... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР ТҮҮНИЙ ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашинны техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Тусгай зориулалтын тоноглогдсон, хөдөлгүүрийн багтаамж 2500 cc дээш	1	95,000,000.00	95,000,000.00
2	Ачааны автомашин, 2.5 тонноос дээш даацтай	2	24,000,000.00	48,000,000.00
3	Ачааны автомашин, 1.2 тонноос дээш даацтай	3	13,500,000.00	40,500,000.00
4	Бохир ус сорох автомашин, 10-20 тонн хүртэл эзэлхүүнтэй	2	48,000,000.00	96,000,000.00
5	Бага оврын автобус, суудлын тоо 8-12, хөдөлгүүрийн багтаамж 2000 cc дээш	3	40,000,000.00	120,000,000.00
6	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 4000 cc дээш	1	168,000,000.00	168,000,000.00
7	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2000 cc хүртэл	4	16,000,000.00	64,000,000.00
	Нийт дүн	16		631,500,000.00 (зургаан зуун гучин нэгэн сая таван зуун мянган)